

Завхан аймгийн Газрын Харилцаа, Барилга, Хот Байгуулалтын Газрын 2023 оны төсөв, санхүүгийн талаарх илтгэх хуудас

Ерөнхий менежер, ерөнхий нягтлан бодогч бид манай байгууллагын 2023 оны 12 сарын 31-ны өдрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланд тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Төсвийн тухай” хуулийн холбогдох заалтын дагуу үнэг зөв, бүрэн тусгасан болохыг баталж байна.Үүнд:

1. Бүх ажил гүйлгээ бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан.
2. Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв хийгдсэн.
3. Байгууллагын үйл ажиллагаа болон санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан.
4. Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардлыг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв тусгасан.
5. Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан ёсны өмчлөлд байдаг бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.

Тус газар нь 2023 онд 46 орон тоотой, **1111555.9** мянган төгрөгийн төсөвтэй ажилласан. Үүнээс:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшилд 924565.6 мянган төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 115310.3 мянган төгрөг
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 126648.2 мянган төгрөг
- Хангамж бараа материалын зардал 10314.3 мянган төгрөг
- Норматив зардал 90.7 мянган төгрөг
- Урсгал засварын зардал 96.8 мянган төгрөг
- Дотоод албан томилолт 3753.9 мянган төгрөг
- Бусдаар гүйцэтгэлүүлэх ажил үйлчилгээний зардал 68791.8 мянган төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал 5190316.4 мянган төгрөг
- Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал 3468.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан ба үндсэн үйл ажиллагааны орлогоос 219858.3 мянган төгрөгийн орлого орж үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Үйл ажиллагааны тогтмол зардал болон бараа үйлчилгээний зардлын төлбөр тооцоог цаг хугацаанд нь гүйцэтгэж, гарах зардалд хяналт тавьж төсвийн гүйцэтгэлийн мэдээг ГХБГЗЗГазрын санхүү аж ахуйн хэлтэс, аймгийн төрийн сангийн хэлтэстэй тооцоо нийлэн сар бүр баталгаажуулан шилэн дансанд холбогдох мэдээллийг хугацаанд нь тавьж ажилласан.

2023 оны үйл ажиллагааны зардлаас Улсын төсөвт 798.6 мянган төгрөг, орон нутагт 464.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.

4. ГЗБГЗЗГазраас хөрөнгийн санхүүжилтээр 1403.0 мянган төгрөгийн бараа материал татан авч хоорондын тооцоог хийв.

Эд хариуцагчын хөрөнгийн тооллогыг хагас бүтэн жилээр хийж, бараа материалын тооцоог улиралаар хийж тооцоог бодож үр дүнг тооцов.

Харилцах дансны гүйлгээг бүрдэл болсон анхан шатны баримтад тулгуурлан хийж, гүйлгээ гарсан тухай бүр бүртгэлд бичилт хийж баримтаа боловсруулж тайлан тэнцэл гаргалаа.

Тайлан бичсэн: Ахлах нягтлан бодогч